

**"ОРЧУУЛАГЧ БОЛОХ ХҮСЭЛТЭЙ ЗАЛУУЧУУДЫН ХОББИ КЛУБ"-ИЙГ
НЭЭН АЖИЛЛУУЛАХ ГЭЖ БАЙНА**

Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Залуучуудын хөгжлийн газар 2018 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн 15:00-18:00 цагуудын хооронд Орчуулагч болох хүсэлтэй залуучуудын хобби клубийн нээлтийн уулзалтыг зохион байгуулах гэж байна.

Энэхүү клубт хамрагдсанаар бичгийн болон аман орчуулга, түүний дотор синхрон орчуулгыг хэрхэн хийх талаарх мэдлэг мэдээлэл, туршлагаас залуучуудад хуваалцах болно.

Орчуулагч болох хүсэлтэй, гадаад хэл сурч буй залуучууд Нийслэлийн Засаг захиргааны 5 дугаар байрны Иргэний танхимд 2018 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн 15:00 цагт болох уулзалтад бүртгүүлж, өргөнөөр хамрагдана уу.

Тус клубийн үйл ажиллагааг нээж Нийслэлийн Залуучуудын хөгжлийн газрын дарга С.Сүх-Очир “ Мэргэжлийн орчуулагч болох нь” сэдвээр залуучуудад лекц унших болно.

/Даваа~Баасан 08:30-17:30 цагуудын хооронд/

Хариуцсан мэргэжилтэн: О.Санжинхандмаа, холбоо барих утас: 9812- 5557
Цахим шуудангийн хаяг: ubyouthdevelopment@gmail.com